



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/20

Өвт

Тооллогын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/500 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Номын сангийн сан хөмрөгийн бүртгэл, тооллого хийх журам”-ын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Соёлын төвийн номын сангийн номын тооллого хийх комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Тооллогын комиссын дарга: Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Гишүүд: Б.Орбиш (Нийгмийн ажилтан)

Г.Баттулга (Соёлын төвийн Хөгжмийн багш)

Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)


Г.Сугар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

И.Маралмаа (Газрын даамал)

Т.Цэнд-Аюуш (Цаг уурч)

2. Номын санд хадгалагдаж байгаа номын тооллогыг 2022 оны 02 дугаар сарын 21-ны дотор үнэн зөв, чанартай явуулж, тооллогын дүнг танилцуулахыг Тооллогын комиссын дарга (Г.Доржханд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

620401039